

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдсан газар огноо: Тавилга ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 11:00 цагт Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Гандан Энхтайвны өргөн чөлөө, 35/2, Шуудангийн гудамж, Ramada/рамада/ зочид буудлын 4 дүгээр давхарын Кристал танхимд эхэллээ.

Тооллогын комиссын дарга О.Ариунзул: Тавилга ХК нь нийт 122.754 ширхэг хувьцаатай байх ба өнөөдрийн ээлжит хуралд 6 хувьцаа эзэмшигчид хүрэлцэж ирсэн нь нийт хувьцааны 62,76% болж байх тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т заагдсаны дагуу хурлын ирц бүрдсэн байна.

Хурлыг нээж хурлын дарга Ц.Байгалмаа: /цаашид “Хурлын дарга” гэх/ үг хэлэв: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хурлыг нээхээс өмнө ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаас ирцтэй холбоотой ганц зүйл тодруулъя. Манай компаний томоохон хувьцаа эзэмшигчид болох Батхүү, Цолмон гуай нар луу яриад ирж байна уу лавлаарай. Хурлын зарыг журмын дагуу хүргэж ажилласан уу.

Нарийн бичгийн дарга: Сая Цолмон гуай руу залгалаа. Утас нь болохгүй байна. ХЭХ-ын зарыг СЗХ-ны Хурлын зар хүргэх журмын дагуу хүргэсэн. UBS болон TV5 телевизээр 2 удаа зарлуулж, Өдрийн сонинд 2 удаа хурлыг зарыг олон нийтэд түгээсэн. Мөн Хөрөнгийн биржийн сайтад хурлын зарын мэдэгдлийг нийтэлсэн байгаа. Мөн журмын дагуу Брокер, диллерийн байгууллагуудад ХЭ хурлын танилцуулга материалыг хүргэж, үйлдвэрийн байран дээр хурлын материалыг байршуулж ажилласан.

Хурлын дарга: За тэгвэл, одоо 11:20 минут болж байна. Хувьцаа эзэмшигчдийн ирц 63%-д хүрч ирц бүрдсэн байх тул Тавилга ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хөтөлбөрийн дагуу эхлүүлъя. Өнөөдрийн ээлжит хурлаар дараах хоёр асуудлыг хэлэлцэж батална. Нэгт, Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг баталгаажуулах, Хоёрт, ТУЗ-ийн гишүүдийг сонгоно. Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр ХЭ-ээс асуух асуулт, санал байгаа бол хэлнэ үү. (Хуралд оролцогчдоос санал гарсангүй) Байхгүй бол ингээд хэлэлцэх асуудлаа батлах уу

Хурлын дарга: (хуралд оролцогчид бүгд зөвшөөрөв) Хэлэлцэх асуудал 100%-ийн саналаар батлагдлаа. Өнөөдрийн хурлаар хэлэлцэх 2 асуудлын тухай товч танилцуулгыг 2023 оноос гүйцэтгэх захирлыг хийж буй миний бие танилцуулъя. Та бүхэнд танилцуулга материалууд хүргэгдсэн байгаа тул бас хараад яваарай (2023 оны үйл ажиллагааны дүгнэлт болон ТУЗ-д нэр дэвшигчдийн тухай танилцуулгыг 25 минут орчим хийв) Танилцуулгатай холбоотойгоор та бүхнээс асууж тодруулах зүйлийг хүлээн авч хариулъя.

Хувьцаа эзэмшигч Ц.Баярмаа: 2023 онд нилээн их засвар үйлчилгээний ажил хийсэн нь түрээсийн орлого нэмэгдэхэд сайнаар нөлөөлсөн гэж дүгнэж байна. Үйлдвэрийн байрны дээврийн ажлын тухай дэлгэрэнгүй тайлбарлаж өгвөл сайн байна.

Хурлын дарга: Компани 2023 ны эхээр татварын нилээдгүй өртэй санхүүгийн хэцүү байдалд байсан. Энэ үед үйлдвэрийн байрыг томоохон хэмжээгээр түрээслэн, урьдчилгааг эхний 3 сараар нь бөөнднө төлөх боломжтой түрээслэгч гарч ирсэн. Бид үүнийг дээврээ засварлах боломж гэж хараад томоохон

засварыг 3 сард эхлүүлж 6 сард дуусгахдаа, шалны хэмжээгээр 1440 мкв талбайн хуучин дээврийг хуулаад, цэвэрлүүлээд 2 давхар чулуутай хар цаасаар хучуулж зассан. Засварт гарсан зардлаа уг талбайг түрээсэлсэн ашгаасаа бараг нөхөж чадсан. Анхнаасаа агуулахын дотуур тавигдсан ус зайлуулах шугам энэ хавар хөлдөөд, ширмэн турба нь хагарч ус алдснаас болоод түрээслэгч нар гарч явсан тул үүнийг нь гадагшаа ус зайлуулдаг болгох шаардлагатай байна.

Хувьцаа эзэмшигч Ч.Баясгалант: Зөв шийдвэр гаргаж сайн ажиллажээ. Гэхдээ цаашид оффис үйлдвэрийн барилга дээрээ зураг төсөл хийх, хөрөнгө оруулалт татах гэх мэтээр урт хугацааны ажлууд хийх нь зөв шүү.

Хурлын дарга: Тийм ээ. 2023 оноос дэд бүтцийн байгууллагуудад жишээ дулааны ашиглалтын хүсэлт явуулах, барилгын дүгнэлт гаргуулах гэх мэтээр ажиллаж байна. Хөрөнгө оруулалтын тухайд одоогоор тоймтой зүйлгүй байна.

Хувьцаа эзэмшигч Ц.Банзрагч: Хөрөнгийн биржид тайлангуудаа өгсөн юмуу?

Хурлын дарга: Хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд аудитаар болон төрийн захиргааны байгууллагаар баталгаажсан санхүүгийн батлагдсан тайлангаа өгч, мөн Хөрөнгийн биржийн сайтад тавигдсан байгаа.

Хувьцаа эзэмшигч Ц.Банзрагч: Энэ компаний гадна хашааг баруун нь тэгшлээд тэлэхгүй яагаад догол үүсгэчиж барьсан бэ.

Хурлын дарга: Уг нь бид одоо компаний эзэмших эрхтэй байгаа газрын кадастраар хашаагаа тэлж барьж эхэлсэн боловч, Нийслэлийн газрын алба, УБЦТ, хороо, дүүргээс янз бүрийн шаардах бичиг ирүүлээд маш хүндрэлтэй байлаа. Мөн намар орой эхэлсэн ажил байсан учир хагас хэмжээгээр сунгаад түр зогсоосон. Цаашид үүн дээр анхаарч ажиллана. Өөр санал дүгнэлттэй хүн байна уу?

Хувьцаа эзэмшигчид: Байхгүй ээ.

Хурлын дарга: Өөр санал байхгүй бол Тооллогын комисс саналын хуудсаа өгөөд саналаа хураая. Хэлэлцэж байгаа асуудал болгоноор та бүхэн кумулятив аргаар саналын тоогоо саналын хуудсанд бичиж саналаа өгнө. Тооллогын комисс хувьцаа эзэмшигчиддээ сайн тайлбарлаад саналыг нь аваарай.

(Тооллогын комисс саналыг нэгтгэх хооронд 10 минут хурал түр завсарлаад үргэлжлэв.)

Хурлын дарга: Тооллогын комисс дүнгээ танилцуулаарай.

Хурлын дарга: Тооллогын комиссын дүнг үндэслэн, Тавилга ХК-ий хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолыг дараах байдлаар баталж байна:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт нийт 6 хувьцаа эзэмшигчдийн 77,035 (100%) саналын тоогоор дэмжигдэн батлагдлаа.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдэд Ц.Банзрагч, Ц.Баярмаа, Ц.Бат-Амгалан, Ч.Баясгалант, Ц.Байгалмаа, Ц.Баянмөнх нар сонгогдлоо. Хараат бус гишүүдэд Ч.Амгалантуяа, Д.Цэцэгмаа, Б.Өлзийбаяр нар сонгогдлоо.

Хурлын дарга: Тус хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурлын дарга хурлыг хаая. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: Х.Баяржаргал

Хурлын дарга



Ц.Байгалмаа